



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 435

Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2, 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалтыг тус тус нэмсүгэй:

1/2 дугаар зүйлд 2.11¹ дэх хэсэг:

“2.11¹. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасан Дотоод хяналтын хөтөлбөртэй байх.”

2. Мөн журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан 2 (Б) дугаар хавсралтын “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж эрхлэх зөвшөөрөл авах өргөдөлд хавсаргах баримт бичгийн жагсаалт”-д дор дурдсан агуулгатай 5, 6 дахь зүйлийг тус тус нэмсүгэй:

“5. Нэмж эрхлэх үйлчилгээний Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”,

“6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4-т заасан Дотоод хяналтын хөтөлбөр”.

3. Мөн журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан 2 (Г) дугаар хавсралтын “Хоёрдогч өглөг байршуулах зөвшөөрлийн өргөдөлд хавсаргах баримт бичгийн жагсаалт”-д дор дурдсан агуулгатай 4 дэх зүйлийг нэмсүгэй:

“4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4-т заасан Дотоод хяналтын хөтөлбөр;”

4. Мөн журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан 2 (Д) дугаар хавсралтын “Нэгж байгуулах зөвшөөрлийн өргөдөлд хавсаргах баримт бичгийн жагсаалт”-д дор дурдсан агуулгатай 6 дахь зүйлийг нэмсүгэй:


“6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4-т заасан Дотоод хяналтын хөтөлбөр”;

5. Мөн журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан 2 (Е) дугаар хавсралтын “Оноосон нэр өөрчлөх зөвшөөрлийн өргөдөлд хавсаргах баримт бичгийн жагсаалт”-д дор дурдсан агуулгатай 5 дахь зүйлийг нэмсүгэй:

“5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4-т заасан Дотоод хяналтын хөтөлбөр”.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН